




Оксфордын
уншлагын
мод

Зугаалга



Родерик Хант
Алекс Бричта



Автобус сургуулийн хашаанд ирж зогсоход хүүхдүүд сууцгаав. Вильф:
- Би гадагшaa зугаалах дуртай гэв.
Харин тэдэнд хатагтай Мей:
- Битгий шахцалдаарай! гэж хэллээ.



Автобус дуу чимээгээр дүүрч, хүүхдүүд
“Ура” хашгирч,

- Бид нар амьтдын хүрээлэн явцгаана
гэцгээв.


- Хүүхдүүд ээ, битгий шуугилд гэж
хатагтай Мей дахин хэллээ.



Биф Чиптэй хамт, Вильф Надимтай хамт суусан байлаа.

- Маш хөгжилтэй байна гэж Надимыг хашгирахад,

- Хэрвээ чи чимээгүй болчихвол бүр ч сайхан байна аа гэж хатагтай Мей хэлэв.



Автобус зам дээр зогч, хүүхдүүд бууцгаав. Зарим нь нуур үзэж, зарим нь бие засах газар орцгоов.



Хатагтай Мей:

- Битгий хол яваарай, бас битгий усанд
ойртоорой гэж хэлэв.



Вильф чулуу өшиглөж байтал түүний
гутал ус уруу цүлхийтэл сугараад
орчихлоо.

- Өө, Вильф! гэж Биф хэлэв.




Вильф гутлаа авч чадахгүй болохоор
энэ тухай хатагтай Мейд хэлэв.

- Ямар тэнэг юм хийдэг юм бэ. Би яаж
авч болохыг мэдэхгүй байна гэж хатагтай
Мей хэллээ.




Тэднийг амьтны хүрээлэнд ирэхэд бороо орж эхлэв. Хүүхдүүд автобуснаас бууж, хатагтай Мей тасалбар авахаар явлаа.



Надим заан үзэхийг хүсч байв. Вильф харин арслан, Биф матар үзэхийг хүсч байлаа.

- Бороо зогсоно гэж найдъя гэж хатагтай Мей хэлэв.



Бороо улам ширүүссээр л байв.
Хүүхдүүд хооллож, амьтад ч мөн хоолоо
идэцгээж байв.

- Битгий нороорой гэж хатагтай Мей
захина.



Бороо зогсохгүй орсоор л байсан тул
хүүхдүүд автобусандаа сууцгаав. Надим:


- Бид нар музей үзэж болох уу? гэж
асуухад, Хатагтай Мей:

- Сайхан санаа байна гэлээ.



Тэд музейд очив.

- Энэих гоё юм. Бид энддинозавруудыг
үзнэ гэж Вильфийг хэлэхэд, Надим:
- Би динозавруудад дуртай гэв.




Тэд динозаврууд уруу гүйлээ. Битгий
гүйлдээрэй, динозаврууд холдоод
явчихгүй гэж хатагтай Мей сануулав.



Тэд маш том динозавр үзэв.

- Үүнийг юу гэдэг вэ? гэж Вильфийг
асуухад, Надим:


- Үүнийг хараахан мэдэхгүй юм байна
аа, явж үзэцгээс гэлээ.



Биф зургийн аппараттайгаа ирсэн байв. Тэр динозаврын зургийг аваад,
- Үүнийг юу гэдэг вэ? гэхэд,
- Үүнийг Апатозавр гэдэг юм гэж Надим хариулав.



Хүүхдүүд нэг өрөөнд очиход тайлбарлагч эмэгтэй тэдэнд дино- завруудын тухай ярьж өгөн, зураг үзүүлэв.



Надим:

- Үүнийг юу гэж нэрлэдгийг би мэднэ,
үүнийг Апатозавр гэдэг гэхэд хатагтай
Мей:

- Сайн байна, Надим гэв.



Хүүхдүүд дэлгүүрт очиж, Вильф динозавруудын тухай ном авав. Надим угсардаг тоглоом авлаа. Энэ нь Апатозаврын загвар байв.



- Би үүнийг гэртээ хийнэ ээ гэж түүнийг хэлэхэд Чип:
- Манай гэрт авчраарай, бид чамд тусална гэв.



Автобус сургууль дээр буцаж ирэхэд тарах цаг болсон байв. Хүүхдүүд бүгд:
- Баярлалаа, энэ өдөр маш сайхан өнгөрлөө гэцгээж байлаа.



Надим:

- Баяртай хатагтай Мей, бид маргааш динозавруудыг зурж болох уу? гэхэд,
- Сайхан санаа байна гэж хатагтай Мей хэлэв.



Надим Вильф хоёр гэртээ Биф Чип хоёртой цуг очлоо. Тэд Чипийн өрөөнд угсардаг тоглоомоо угсарч эхлэв.



Гэтэл шидэт түлхүүр туяарч эхэллээ.
Биф хайрцаг уруу гүйж очоод түүнийг
шүүрч аваад.

- Алив, нааш ирцгээ. Одоо ид шидийн
аяллын цаг гэж хэлэв.



- Алив ээ Надим, бид динозавруудын нутагт ид шидээр аялах болно гэж Чип хэллээ.



Оксфордын
уншлагын
мод

Шатлал 6
Түүхүүд

Зугаалга

Борооноос болоод сургуулийн
аялал бараг л болж
байх шиг харин Надимд
өөр санаа төрлөө.



INTERPRESS

Хэвлэн нийтлэлийг
Интерпресс XXX

READ
Rural Education and
Development

Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.